“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 30 Улаанбаатар хот

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлтүүд			
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хүрсэн түвшин	Биелэлтийн хувь
1	**2**	**3**	**4**	**5**	**6**
Нэг. Үйл ажиллагааны хүрээнд					
1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Газрын даргаар батлуулах	Гишүүд төлөвлөгөөг хурлаар хэлэлцсэн байх	Оны анхдугаар хурлаар төлөвлөгөөг хэлэлцэн, Газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах	“Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 98.1 хувьтай хэрэгжив.	100 хувь
2	Ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг цаасан болон цахим хэлбэр (QR код)-ээр хүлээн авч бүртгэх, холбогдох арга хэмжээ авах	Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоох	Ирүүлсэн материалыг шалгаж ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авах	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан тухай нийт 5 албан хаагчтай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган тогтоож, холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд Газрын даргын тушаалаар сануулах арга хэмжээг авсан. Үүнд: - Албан хаагчдын хороонд үүссэн маргааны улмаас ёс зүйн зөрчил гаргасан нийт 3 албан хаагчийн асуудлыг хэлэлцэн, холбогдох хууль журмын хүрээнд Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/21, Б/22, Б/23 дугаар тушаалаар сануулах арга хэмжээ авсан. - Манай газрын нэр бүхий албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай www.shugel.mn, www.tac.mn зэрэг сайтуудад нийтлэгдсэн гомдол, мэдээллийг хүлээн авч Газрын Ёс зүйн дэд хорооны 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцэн Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон байгууллагын дотоод журам, ажилтны ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэж, дүгнэлт	100 хувь

				гаргасан. Дүгнэлтийг үндэслэн Газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/106, 107 дугаар тушаалаар сануулах арга хэмжээ авсан. Гаргасан шийдвэр, дүгнэлт, холбогдох материалыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 05-06/5052 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.	
3	Ёс зүйн зөрчлүүдийн шийдвэрлэлтийн үр нөлөө	Ёс зүйн зөрчлийн талаарх баримтад үндэслэн хариу арга хэмжээ авах	Ёс зүйн зөрчилд холбогдогчтой ярилцах, хуулийн хүрээнд холбогдох ажиллагаа хийгдсэн байх	Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн 3 албан хаагч, Ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчтай уулзаж ярилцан, хурлаар хэлэлцүүлж, холбогдох хуулийн хүрээнд сануулах арга хэмжээг авч ажилласан. Үүнд: Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/21, Б/22, Б/23, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/106, 107 дугаар тушаалаар нийт 5 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ноогдуулан, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллав. *Графикаар харуулбал:* 	100 хувь
4	Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалах	Хувийн хэрэгт хадгалагдсан шийдвэрийн биелэлтийг тооцох	Төрийн албаны зөвлөлийн тогтоол болон, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байх	Сануулах сахилгын шийтгэл ноогдуулсан Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/21, Б/22, Б/23, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/106, 107 дугаар тушаалуудыг албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргав.	100 хувь

5	Ёс зүй, харилцаа хандлагын талаарх судалгааг ажилтан, албан хаагчдаас авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах	Зан харилцааны талаарх судалгааны асуулга боловсруулан, үр дүнг нэгтгэх	Судалгааг цахим платформ (QR код) хувилбараар авч, үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон Зөвлөмж гаргах	"Ёс зүйн дэд хороо"-ны гишүүд “Ажилтны ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар нийт 14 асуулга боловсруулан Газрын дотоод сүлжээнд цахим платформ (холбоос линк, QR код байршуулан) ашиглан 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 03-ны өдрүүдэд судалгааг авч, үр дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулсан. Судалгаанд нийт 83 ажилтан, албан хаагчдаас 60 хүн хамрагдсан ба 2023 онтой харьцуулахад ажилтан, албан хаагчдын хамрагдалт 9,6 хувиар өссөн оролцоотой байна. Судалгааны дүгнэлт, зөвлөмжийг постер хэлбэрээр Газрын дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагч нарт танилцуулав. Мөн мэдээллийн самбар дахь “Ёс дэд хороо” хэсэгт "Дүгнэлт, зөвлөмж"-ийг байршуулав.  	100 хувь

				 **ДҮГНЭЛТ** Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Ёс зүйн дүрэм, “Ажилтны ёс зүй, харилцаа хандлага”-ын талаарх судалгааны үр дүнг үндэслэн дараах дүгнэлтийг хүргүүлж байна. 1. Хэлтсийн дарга нар ажилтан, албан хаагчидтай харилцахдаа өдөр тутмын харилцаандаа мэндлэх соёлыг сайжруулан, харилцан бие биеэ хүндэтгэх, Ажлын байранд найрсаг харилцаа хандлага, уур амьсгалыг бүрдүүлэн манлайлах. 2. Ахлах мэргэжилтнүүд ажилтан, албан хаагчидтай харилцах харилцаа хандлагадаа анхааран, ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан, өөрөө үлгэрлэн манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх. 3. Ажилтан, албан хаагчид ажлын байранд зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандан, хамт олны дунд ажил хэрэгч байдлыг эрхэмлэх. 4. Нийт ажилтан, албан хаагчид ажлын байранд албаны бус хувцаслах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, зохисгүй биеийн хэлэмж, зан авир гаргахыг цээрлэн, ажил үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн хэм хэмжээг баримтлах. **Ёс зүйн дэд хороо** **2024.05.28**	
6	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, танилцуулга, мэдээлэл түгээх	Удирдамж боловсруулан, дүрмийн хэрэгжилтийг хангах	Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангасан байх, удирдамжийн хүрээнд гарсан үр дүнг цахим хуудас болон дотоод сүлжээгээр ил тод мэдээлэх	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ёс зүйн дүрэм”-ийг газрын даргын 2023 оны А/69 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаарх мэдэгдлийг 1, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, холбогдон гарсан дүрмийг таниулах чиглэлийн мэдээллийг нийт 3 удаа тус тус Газрын дотоод цахим хуудаснаа байршуулан ажилласан.  **НИЙТ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН АНХААРАЛД** Ажилтан, албан хаагчид ажлын цаг ашиглалтад АНХААРЧ, Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Ажилтны Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган, ажил албан үүргээ гүйцэтгэхдээ гүйцэтгэгч байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, Ёс зүйн дөгөлдөл гаргахгүй үйлчилж ажлын бүтээмжийг сайжруулан, холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөж ажиллана уу. **ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС**  ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО	100 хувь

				 ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА **9 дүгээр зүйл.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа** 9.1.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1, 10.2-т заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 9.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах; 9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх; 9.1.3.урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах; 9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн харилцага хүлээсэн эсэхийг харгалзах; 9.1.5.иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх. 9.2.Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг батлаж, мөрдүүлнэ. ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО	
7	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах	Дүрэм, журмын талаар мэдлэг олгоно, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэнэ	Дүрэм, журмыг танилцуулан гарын үсгээр баталгаажуулсан байна, газрын хэмжээнд мөрдөж буй дүрэм, журмыг баримтлан ажиллах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил үр дүнд хүрсэн байна	Шинээр ажилд томилогдсон нийт 27 албан хаагч нарт Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 8-ны өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан Газрын “Хөдөлмөрийн дотоод журам”, 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан Газрын “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг тухай бүр танилцуулав.	100 хувь
8	Удирдах албан тушаалтны ёс зүйн талаар судалгаа авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах	Судалгааны асуулга боловсруулах	Судалгааг авч, үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон Зөвлөмж гарсан байх	Удирдах албан тушаалтны ёс зүйн талаар судалгаанд 39 ажилтан хамрагдсан байна. Үүнээс: • 8 ажилтан буюу 21% нь Маш сайн • 19 ажилтан буюу 49% нь Сайн • 8 ажилтан буюу 21% нь Дунд • 3 ажилтан буюу 8% нь Тааруу • 1 ажилтан буюу 3% нь Муу гэж хариулжээ. Эдгээр үзүүлэлтээс дүгнэвэл: Нийт ажилтан, албан хаагчид удирдах албан тушаалтны харилцаа хандлага,	90 хувь

				ёс зүйг дийлэнх нь "**САЙН**" гэж үзэж байна.	
9	Дэлхийн ёс зүйн өдрийн хүрээнд Аян зохион байгуулах	Дотоод зохион байгуулалт хангах, удирдамж боловсруулах	Удирдамжийн дагуу аян зохион байгуулж илтгэх хуудсаар баталгаажуулан, ажилтнуудад мэдээлэл хүргүүлсэн байх	Монгол Улсын "Ёс зүйн хороо"-ноос 2024 оны 11 дүгээр сарыг "Ёс-той Зүйтэй" сар болгон зарласан. Манай газар тус аянд нэгдэж "Ёс-той Зүйтэй" аяны удирдамж, төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдөр хүртэл аяны үйл ажиллагааг зохион байгуулав. Аяны хүрээнд 7 хэлтэс тус бүр 5 удаа, нийт 35 удаа эрэг уриалга мэндчилгээ, аяны удирдамжийн дагуу зөвлөмж, постер 5 удаа (Аянд идэвхтэй хамрагдахыг уриалсан мэдээлэл-1, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим" постер, мэдээлэл-1,"Соёлтой хувцаслая" уриалга, мэдээлэл-1, Ажлын байрны зөв зохистой хувцаслалт зөвлөмж, мэдээлэл-1, Ажлын цаг төлөвлөлт зөвлөмж, мэдээлэл-1) нийт 40 удаагийн мэдээлэл бэлтгэн газрын телеграмм группээр дамжуулан албан хаагчдад хүргэж, уриалж ажилласан. "Дэлхийн ёс зүйн өдөр"-ийн тохиолдуулан Газрын нийт албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг анхаарч, "Better Mind" нойргүйдэл, сэтгэл заслын эмнэлэгтэй хамтран 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал "Стрессийн түвшин тогтоох, бие хүний сэтгэл зүй" тест, сорилыг газрын албан хаагчдаас авав. Стрессийн түвшин тогтоох сорилд 75, Бие хүний сэтгэл зүйн сорилд 73 албан хаагч тус тус хамрагдав. Судалгааны үр дүнг албан хаагч тус бүрийн хувийн мэйл хаягаар илгээж, нэгдсэн тайланг гаргаж, удирдлагын багт 12 дугаар сарын 16-ны өдөр танилцуулав.	100 хувь
10	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг	Уриалга, санамж, зөвлөмжийг хууль, дүрэм, журмын хүрээнд боловсруулан хүргүүлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангах, бусад холбогдох дүрэм, журмын	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын "Ёс зүйн дүрэм"-ийг газрын даргын 2023 оны А/69 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Газрын "Ёс зүйн дүрэм"-ийг мөрдөж ажиллах талаарх мэдэгдлийг 1, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, холбогдон гарсан дүрмийг таниулах чиглэлийн мэдээлэл 3, "Ажилтны ёс зүй, харилцаа хандлага"-ын талаар нийт албан хаагчдаас авсан судалгааны	100 хувь

	болгон ажиллах		хэм хэмжээний хэрэгжилт хангах	дүгнэлтэд үндэслэн гаргасан зөвлөмж 1, Ажлын байранд “Электрон тамхи” хэрэглэхгүй байх тухай уриалга 1, нийт 6 удаагийн мэдээллийг Газрын дотоод сүжээнд байршуулан албан хаагч нарт хүргэж ажилласан. Мөн мэдээллийн самбар дахь “Ёс дэд хороо” хэсэгт "Дүгнэлт, зөвлөмж"-ийг байршуулав. 	
11	Ёс зүйн талаарх мэдээ, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тогтоосон хугацаанд хүргүүлэх	Тухай бүр тайланг нэгтгэх	Тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллах	Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жилийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2252 дугаар албан бичгээр, 3 дугаар улирлын биелэлтийг 11 дүгээр сарын 4-ний өдөр erdenemunkh.@ulaanbaatar.mn цахим хаягаар тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт илгээсэн. Жилийн эцсийн байдлаар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж хүргүүлэхээр бэлтгэж байна. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он)-ийн төсөл, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын төслийн хүрээнд санал авах ажлыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, саналыг 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 5/828 албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	100 хувь

12	Ёс зүйн дэд хорооны хагас, бүтэн жилийн тайланг Газрын даргад танилцуулах	Тухай бүр тайланг нэгтгэх	Төлөвлөгөөний хэрэгжилт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох	Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Газрын даргад танилцуулсан. Жилийн эцсийн байдлаар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж , Газрын даргад танилцуулахаар бэлтгэж байна.	100 хувь
13	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх холбогдох материалын бүрдлийг ханган Газрын Архивд хүлээлгэн өгнө	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Архивд бүрэн хүлээлгэн өгнө	Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааны холбогдох баримт бичгийг архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэн Газрын архивд хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.	80 хувь
Хоёр. Сургалт, соён гэгээрэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа					
1	Нийт ажилтан, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн талаарх сургалт зохион байгуулах	Төлөвлөгөө боловсруулан сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах	Сургалт зохион байгуулан, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байх	Төрийн албан хаагчийн тухай хууль, холбогдох дүрэм журмыг таниулах чиглэлээр нийт 11 удаагийн сургалтад 70 албан хаагч хамрагдав. Үүнд: 1. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдаж 4 албан хаагч, 2. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалт 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж 2 албан хаагч, 3. "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт богино хугацааны сургалт 2024 оны 03 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 1, 4. “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж 2 албан хаагч, 5. “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалт 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж 4 албан хаагч,	100 хувь

				6. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалт 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж 1 албан хаагч, 7. "Төрийн албан хаагчийн ёс зүй, эрх зүйн зохицуулалт" сургалт 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж 38 албан хаагч, 8. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалт 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж 1 албан хаагч, 9. "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх" сургалт 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж 2 албан хаагч, 10. "Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдаж 5 албан хаагч, 11. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж 10 албан хаагч нийт 10 сургалтад давхардсан тоогоор 70 албан хаагч тус тус хамрагдав.	
2	Ёс зүйн алдаа, зөрчил гаргах, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах	Дотоод зохион байгуулалт хангах (мэдээллийн самбар, цахим хэлбэр)	Нөлөөллийн видео контент түгээж, газрын үйл ажиллагааны онцлог болон цаг үеийн шинжтэй үйл явдалд илэрч болзошгүй ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлэх	Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаарх мэдэгдлийг 1, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, холбогдон гарсан дүрмийг таниулах чиглэлийн мэдээлэл 3, нийт 4 удаагийн мэдээллийг Газрын дотоод цахим хуудаснаа байршуулан ажилласан. “Ажилтны ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар нийт албан хаагчдаас авсан судалгааны дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг постер хэлбэрээр Газрын дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагч нарт танилцуулав. Мөн мэдээллийн самбар дахь “Ёс дэд хороо” хэсэгт "Дүгнэлт, зөвлөмж"-ийг байршуулав.	100 хувь

				Ажлын байранд “Электрон тамхи” хэрэглэхгүй байх тухай уриалгыг бэлтгэн дотоод сүлжээнд байршуулан албан хаагч нарт хүргэсэн.   	
3	Ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар дотоод ажил зохион байгуулах	Төлөвлөгөө боловсруулах, дотоод зохион байгуулалт хангах	Сахилга, хариуцлага дээшлэн, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдах	“ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, эерэг нөлөөлөл бий болгох зорилгоор “Би чамаас-Чи надаас” сэдэвт урам өгөх хүндэтгэлийн захидлыг албан хаагчид бие биедээ бичиж, аянд нэгдсэн.   Монгол Улсын “Ёс зүйн хороо”-ноос 2024 оны 11 дүгээр сарыг “Ёс-той Зүйтэй” сар болгон зарласан. Манай газар тус аянд нэгдэж “Ёс-той Зүйтэй” аяны удирдамж, төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдөр хүртэл аяны үйл ажиллагааг зохион байгуулав. Аяны хүрээнд 7 хэлтэс тус бүр 5 удаа, нийт 35 удаа эерэг уриалга мэндчилгээ, аяны удирдамжийн дагуу зөвлөмж, постер 5 удаа (Аянд идэвхтэй хамрагдахыг уриалсан мэдээлэл-1, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим” постер, мэдээлэл-1,“Соёлтой хувцаслая”	100 хувь

				уриалга, мэдээлэл-1, Ажлын байрны зөв зохистой хувцаслалт зөвлөмж, мэдээлэл-1, Ажлын цаг төлөвлөлт зөвлөмж, мэдээлэл-1) нийт 40 удаагийн мэдээлэл бэлтгэн газрын телеграмм группээр дамжуулан албан хаагчдад хүргэж, уриалж ажилласан. Газрын нийт албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг анхаарч, "Better Mind" нойргүйдэл, сэтгэл заслын эмнэлэгтэй хамтран 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал “Стрессийн түвшин тогтоох, бие хүний сэтгэл зүй” тест, сорилыг газрын албан хаагчдаас авав. Стрессийн түвшин тогтоох сорилд 75, Бие хүний сэтгэл зүйн сорилд 73 албан хаагч тус тус хамрагдав. Судалгааны үр дүнг албан хаагч тус бүрийн хувийн мэйл хаягаар илгээж, нэгдсэн тайланг гаргаж, удирдлагын багт 12 дугаар сарын 16-ны өдөр танилцуулав.	
Дундаж хувь					98,1 хувь

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН “ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”